



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл орчмын бүс нутагт 2019 оны 4, 5 дугаар сард хуурай салхитай, түймэр ихтэй, олон жилийн дунджаас бага хур тунадастай 6 дугаар сард мөн энэ байдал үргэлжлэх төлөвтэй байгаа тул Нийслэл орчмын бүс нутгийн зуншлагын байдлыг сайжруулах, ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарт нөлөөлж зориудаар хур тунадас нэмэгдүүлэх талаар Цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.


2. Цаг агаарт нөлөөлж зориудаар хур тунадас нэмэгдүүлэх ажлын зардлыг хавсралт ёсоор баталсугай.

3. Батлагдсан 5000000 /Таван сая/ төгрөгийн зардлыг Ногоон байгууламжийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 07 сарын 29  
өдрийн 2019/07/29 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛ ОРЧМЫН БҮС НУТАГТ ЦАГ АГААРТ ЗОРИУДААР  
НӨЛӨӨЛЖ ХУР ТУНАДАС НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Бүгд үнэ /төг/
1	Экспедицийн ажиллах томилолтын зардал	2.000.000,00
2	Экспедицийн ажиллах татахууны зардал	3.000.000,00
3	БҮГД	5.000.000,00